



ХЭНТИЙ АЙМАГ  
БОР-ӨНДӨР СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 5/20

Бор-Өндөр

Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл, 16.5.5 дахь заалт, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 9 дүгээр зүйлийн 9.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдэх, өвөлжилтийн байдал хүндэрч амьсгалын замын өвчлөл ихсэж байгаатай холбогдуулан тус төвийн багш, ажилтнуудад нийт 384,000 (гурван зуун наян дөрвөн мянга) төгрөгийн дархлаа дэмжих бүтээгдэхүүн олгосугай.

2. Дээрх зардлыг холбогдох зардлаас зарцуулахыг нягтлан бодогч /М.Мөнхцэцэг/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА ..... М.ЧУЛУУНЦЭЦЭГ

